



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 5/45

Улаанбаатар хот

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.3.2 дэх хзаалт, 4.4, 4.6, 5.1 дэх хэсэг, "Сав газрын захиргаад байгуулах тухай" 2012 оны 254 дүгээр тогтоол, "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 2014 оны 332 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 01/7000 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Тус яамны харьяа Хөвсгөл аймаг дахь Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Баярсайханы Ундармааг 2017 оны 10 дугаар сарын // -ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Б.Ундармаагийн албан тушаалын цалинг ТЗ-8-1 шатлалаар 639 024 /зургаан зуун гучин есэн мянга хорин дөрвөн/ төгрөгөөр адилтган тооцож, олгохыг Санхүүгийн хэлтэс /Б.Нансалмаа/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Гүндсамбуу/, тус сав газрын захиргааны нягтлан бодогч нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Р.Одонбаатар, Б.Ундармаа нарын ажил үүрэгтэй холбоотой байгууллагын тамга, тэмдэг, баримт бичиг /файл/ болон эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг хүлээлцүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Х.Батжаргал, Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмар, Сав газрын удирдлагын хэлтсийн дарга Н.Баттулга, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Нансалмаа нарт тус тус үүрэг болгосугай.

4.Б.Ундармаатай ажлын байр (албан тушаал)-ын тодорхойлолтын дагуу үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмар, Сав газрын удирдлагын хэлтсийн дарга Н.Баттулга, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Х.Батжаргал нарт тус тус даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОЮУНХОРОЛ